# 2022 оны Бондын санал асуулга

# November 8, 2022

| | |
|---|---|
| Метро болон бусад тээврийн хэрэгсэл | **<u>АСУУЛГА:</u> Арлингтон хот нь Вашингтон Метрополитан мужийн Транзит дамжин өнгөрөх бүс газар (WMATA -ВМТДБ) болон бусад тээвэр, явган зорчигч, зам, тээврийн төслүүдийг санхүүжүүлэхэд зориулан зээлийн гэрээ байгуулж, үндсэн зээлийн дээд хэмжээ нь $52,630,000 байхаар ерөнхий зээлийн хэрэглээ, зориулалтыг тогтоож, бондын хөрөнгө босгох нь зүйтэй эсэх тал дээр?**<br><br>**<u>ТАЙЛБАР МЭДЭГДЭЛ:</u>** Энэхүү төсөл нь улс орны дамжин өнгөрөх төрөл бүрийн тээврийн хэрэгсэл, зам тээвэр, явган хүний гарц, бусад тээвэр дамжих зурвасын аливаа төслийг санхүүжүүлэх юм. Энэ төрлийн төслүүдийн урьдчилсан төсөв өртөг нь төсөлд санал болгосон дүнгээр буюу (WMATA -ВМТДБ)/Метро тээврийн хэрэгслийг сайжруулах төсөл хөтөлбөр-ийн Арлингтон мужид ногдох хэсгийг санхүүжүүлэхэд нийтдээ 42.6 сая ам. Доллар, мөн 7.2 сая ам. Доллар нь орон нутгийн зам талбай, гудамж хэсгийг хатуу хучилттай болгоход, 1.5 сая ам. Доллар нь зам гүүрний засварын ажилд, 1.1 сая ам. Доллар нь зам, гудамжны гэрэлтүүлэгт, 0.2 сая ам. Доллар нь ухаалаг тээврийн хэрэгслийн систем шинэчлэн суурилуулах ажилд, мөн 0.1 сая ам. Доллар нь замын хажуугийн үер усны суваг шуудуун засварын ажилд зарцуулахаар төсөвлөжээ. Мужийн удирдах зөвлөлөөс бондын хөрөнгийг дахин төлөвлөлтийн хүрээнд шаардлагатай нөхцөлд аливаа шинэчилсэн төлөвлөгөөний дагуу бусад тээврийн төслүүдийн дунд дахин хуваарилалт явуулах болно. |
| Тухайн бүс нутгийн цэцэрлэгт хүрээлэн, амралт зугаалгын газрууд | **<u>АСУУЛГА:</u> Арлингтон хот нь бүс нутгийн цэцэрлэгт хүрээлэн, амралт зугаалгын газруудыг хөгжүүлэх зорилгоор аливаа боломжит төслүүдийг санхүүжүүлэхэд зориулан зээлийн гэрээ байгуулж, үндсэн зээлийн дээд хэмжээ нь $22,460,000 байхаар ерөнхий зээлийн хэрэглээ, зориулалтыг тогтоож, бондын хөрөнгө босгох нь зүйтэй гэж үзэж байна уу?**<br><br>**<u>ТАЙЛБАР МЭДЭГДЭЛ:</u>** Энэхүү төсөл нь төрөл бүрийн амралт зугаалга, цэцэрлэгт хүрээлэнгийн төслүүдийг санхүүжүүлэх зорилготой юм. Энэ төрлийн төслүүдийн урьдчилсан төсөв өртөг нь $10.8 сая ам.Долларыг амралт зугаалгын газрууд, цэцэрлэгт хүрээлэнг сэргээн засварлах мастер төлөвлөгөөг санхүүжүүлэхээр төсөвт тусгаж, мөн Женни Дин(Jennie Dean) соёл амралтын хүрээлэнгийн 2-р ээлжийн ажилд 4.4 сая ам.Долларыг, Арлингтон хотын Boathouse/завь түрээсийн үйлчилгээнд 2.9 сая ам.Долларыг, Байгалийн зохилдлого сэргээн засах хөтөлбөрт нийтдээ 2.0 сая ам.Долларыг, Шинээр гарч буй хэрэглээний хөтөлбөрүүдэд дахин 2.0 сая ам.Долларыг, синтетик зүлэгжүүлэлтийн ажилд нийтдээ 0.3 сая ам.Долларыг тус тус зарцуулахаар төсөвлөжээ. Мужийн удирдах зөвлөлөөс бондын хөрөнгийг дахин төлөвлөлтийн хүрээнд шаардлагатай нөхцөлд аливаа шинэчилсэн төлөвлөгөөний дагуу бусад соёл амралтын хүрээлэн, амралт зугаалгын газруудын холбогдох төслүүдэд дахин санхүүжүүлэлтийн хуваарилалт явуулах болно. |
| Дэд бүтцийн асуудал | **<u>АСУУЛГА:</u> Арлингтон хот нь бүс нутгийн дэд бүтэц, шугам, дулаан, тэдгээрийн барилга байгууламжийн засвар үйлчилгээний ажлууд, зураг төсөл, Арлингтон хотын хөрш нутгуудын төсөл хөтөлбөр, үүгээр хязгаарлагдахгүй бусад мужийн дэд бүтцийн асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор аливаа боломжит төслүүдийг санхүүжүүлэхэд зориулан зээлийн гэрээ байгуулж, үндсэн зээлийн дээд хэмжээ нь $53,300,000 байхаар ерөнхий зээлийн хэрэглээ, зориулалтыг тогтоож, бондын хөрөнгө босгох нь зүйтэй гэж үзэж байна уу?**<br><br>**<u>ТАЙЛБАР МЭДЭГДЭЛ:</u>** Энэхүү төсөл нь төрөл дэд бүтцийг хөгжүүлэх төслүүдийг санхүүжүүлэх зорилготой юм. Энэ төрлийн төслүүдийн урьдчилсан төсөв өртөг нь 13.1 сая ам.Долларыг төр захиргааны байгууллага, шүүх цагдаагийн барилгын ажилд, нийтдээ 12.7 сая ам Долларыг барилга байгууламжийн зураг төсөл, барилгын ажилд, 12.0 сая ам.Долларыг шүүхийн байрны дахин сэргээн босгох, дэд бүтцийнй ажилд, мөн 7.4 сая ам Долларыг гал унтраах станц дахин суурилуулалтын ажил болон нэмэлт ажлуудад төсөвлөсөн бол 5.0 сая ам Долларыг Хөршийн санд тусгаж, 3.1 сая ам Долларыг барилгын дэд бүтцийн засвар үйлчилгээний ажилд тус тус зарцуулахаар тооцжээ. Мужийн удирдах зөвлөлөөс бондын хөрөнгийг дахин төлөвлөлтийн хүрээнд шаардлагатай нөхцөлд аливаа шинэчилсэн төлөвлөгөөний дагуу мужийн аливаа дэд бүтцийн холбогдох төслүүдэд дахин санхүүжүүлэлтийн хуваарилалт явуулах болно. |

ARLINGTON
VIRGINIA

# 2022 оны Бондын санал асуулга

# November 8, 2022

### Арлингтон мужийн төрийн өмчит сургуулиуд

**<u>АСУУЛГА:</u> Арлингтон хот нь тус мужийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аливаа төрийн өмчит сургуулиудад холбогдох төрөл бүрийн төслүүдийг санхүүжүүлэхэд зориулан зээлийн гэрээ байгуулж, үндсэн зээлийн дээд хэмжээ нь $165,010,000 байхаар ерөнхий зээлийн зориулалтыг тогтоож, бондын хөрөнгө босгох нь зүйтэй юу?**

**<u>ТАЙЛБАР МЭДЭГДЭЛ:</u>** Энэхүү төсөл нь Арлингтон мужийн төрийн өмчит сургуулиудын сэргээн хөгжүүлэх зорилгоор аливаа боломжит санхүүжилтийг оруулахаар төлөвлөж байна. Эдгээр төслүүдийн төсөвлөсөн зардал нь дараах санхүүжилт шаардлагатай гэж үзэв:

- Карееr хөгжлийн төв байгуулах төсөлд ($135,970,000)
- Гал тогоо, орох хэсэг/харуул хамгаалалтын хэсгийг дахин шинэчлэх төсөл хөтөлбөрт ($12,240,000)
- Голлох дэд бүтцийн төслүүдэд ($16,800,000)

Сургуулийн зөвлөл нь Сургуулийн төлөөлөн удирдах удирдлагын сургууль хөгжүүлэлтийн төлөвлөгөөний дагуу холбогдох сургуульд хамаарах төслүүдэд бонд хуваарилах тухай асуудалд шаардлагатай нөхцөлд цаг тухай бүрт дахин авч үзэх болно.

### Үер усны далан сэтлэн гаргах ажилд

**<u>АСУУЛГА:</u> Арлингтон хот захиргаа нь тухайн нутаг дэвсгэрт үер уснаас хамгаалах шуваг шуудуу далан барих төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэхэд зориулан зээлийн гэрээ байгуулж, үндсэн зээлийн дээд хэмжээ нь $39,760,000 байхаар ерөнхий зээлийн зориулалтыг тогтоож, хөрөнгө тогтоох нь зөв гэж үзэж байгаа юу?**

**<u>ТАЙЛБАР МЭДЭГДЭЛ:</u>** Энэхүү төслийн санал нь тухайн нутаг дэвсгэрт төрөл бүрийн суваг шуудуу, үер усны далан сэтлэн гаргах төслүүдийг санхүүжүүлэх юм. Эдгээр төслүүдийн нийт зардлын дараах байдлаар санхүүжүүлэх санал оруулав:

<u>Багтаамж цар хүрээг нэмэгдүүлэхэд</u>

- Усны хагалбар бүхий газарт ($13,260,000)
- Лангстоны өргөн чөлөө болон /Сикамор гудамжны ус дамжуулах хоолойн хэсэг ($6,750,000)
- Торрейсон усны хагалбар газрууд ($5,955,000)
- Бусад багтаамж цар хүрээг өргөтгөх төслүүдэд зориулан ($8,025,000)

<u>Усны чанарыг сайжруулах тал дээр</u>

- Персийн булангаас ирэх усны урсгал ($2,750,000)
- Шувуудын цөөрмийн усны урсгал ($1,275,000)
- Бусад усны чанарыг сайжруулахад ($1,745,000)

Мужийн захиргааны зөвлөл нь тус бүс нутгийн хөгжүүлэлтийн төлөвлөгөө, түүнд шаардлагатай үед нэмэлт өөрчлөлт оруулах замаар цаг тухай бүрт үер, усны суваг шуудуу, далан сэтлэн гаргах төслүүдийг санхүүжүүлэх төсөв дахин хуваарилах болно.

### Хотын болон нийтийн хэрэглээний зардал

**<u>АСУУЛГА:</u> Арлингтон хот захиргаа нь тухайн нутаг дэвсгэрт нийтийн хэрэглээний зардалд хамаарах цэвэр бохир усны хяналтын станц байгуулах, усны бохирдлыг бууруулах болон тус мужид цэвэр, бохирын системийг төлөвлөх, өргөтгөн сайжруулах, шинэчлэх зардал, цэвэр бохир усны системтэй холбох, дахин төлөвлөлтийн зардлыг хөтөлбөрийг санхүүжүүлэхэд зориулан зээлийн гэрээ байгуулж, үндсэн зээлийн дээд хэмжээ нь $177,360,000 байхаар ерөнхий зээлийн зориулалтыг тогтоож, хөрөнгө тогтоох нь зөв гэж үзэж байгаа юу?**

**<u>ТАЙЛБАР МЭДЭГДЭЛ:</u>** Энэхүү төслийн зорилго нь мужийн бохир усыг боловсруулах, цэвэр бохир усны дэд бүтцийг сайжруулахад шаардлагатай шинэчлэлт хийх санхүүжилтийг хийх юм. Энэ төрлийн төслүүдэд тооцоолж буй нийт зардлыг төсөвлөж, байгальд ээлтэй Бохир усыг боловсруулах Хяналтын Станцыг байгуулахад $159.5 сая ам.долларыг тооцож, мөн энэ нь тус нутаг дэвсгэрт хүн амны өсөлтөд тулгуурлан нэмэлт станцуудыг барих, хүчин чадлыг нэмэгдүүлэхэд орших бөгөөд Вашингтоны усан сувгийн системийг сайжруулахад 15.0 сая долларыг, таталцлаар цахилгаан дамжуулах сүлжээг хөгжүүлэх ажилд 2.9 сая долларыг тус тус зарцуулахаар тусгажээ. Хотын зөвлөл мөн хот хөгжүүлэлтийн төлөвлөгөөний дагуу хотын болон олон нийтийн хэрэглээний зардал түүнд хамаарах аливаа төсөлд шаардлагатай цаг тухай бүрт нэмэлт өөрчлөлт оруулж, төсөв хуваарилах тухай авч үзэх болно.